



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 3.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох нийт 1,095,413,814.3 (нэг тэрбум ерэн таван сая дөрвөн зуун арван гурван мянга найман зуун арван дөрвөн төгрөг гучин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 673,470,812.53 (зургаан зуун далан гурван сая дөрвөн зуун далан мянга найман зуун арван хоёр төгрөг тавин гурван мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Л.Насанцэнгэл нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000080

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 02 дугаар сарын 11-ний
өдрийн... 09... дугаар тогтоолын хавсралт

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн дансны ангилал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын нийт үнэ /төгрөг/		Цаашид ашиглах хугацаа (жил)
				Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн	Үнийг шинэчлэн тогтоох	
1	Машин тоног төхөөрөмж (компьютер) 154 нэр төрөл	ш	15	10,022,731.00	6,130,563.00	1
2		ш	356	558,264,095.97	276,556,920.03	2
3		ш	81	288,763,500.00	213,665,932.50	3
4		ш	10	105,240,400.00	53,314,320.00	4
	Бүгд дүн		462	962,290,727.00	549,667,735.53	
5	Тавилга эд хогшил 174 нэр төрөл	ш	9	2,415,890.00	1,072,860.50	1
6		ш	364	51,487,979.12	45,447,027.16	2
7		ш	201	32,778,885.89	37,425,625.49	3
8		ш	91	9,350,625.00	12,022,610.00	4
9		ш	7	1,388,109.30	826,054.65	5
10		ш	2	7,745,000.00	4,647,000.00	6
	Бүгд дүн		674	105,166,489.30	101,441,177.80	
11	Бусад үндсэн хөрөнгө 23 нэр төрөл	ш	10	2,088,216.00	1,828,547.20	2
12		ш	6	12,613,575.00	7,505,145.00	3
13		ш	10	6,255,807.00	6,029,207.00	4
14		ш	1	6,999,000.00	6,999,000.00	5
	Бүгд дүн		27	27,956,598.00	22,361,899.20	
	Нийт дүн		1163	1,095,413,814.30	673,470,812.53	
				(нэг тэрбум ерэн таван сая дөрвөн зуун арван гурван мянга найман зуун арван дөрвөн төгрөг гучин мөнгө)	(зургаан зуун далан гурван сая дөрвөн зуун далан мянга найман зуун арван хоёр төгрөг тавин гурван мөнгө)	